



ТӨРИЙН МЭДЭЭЛЭЛ

№ 32 (317)

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ:

- *Гевьяат цол хүртээж, одон, медалиар шэгнасан тухай*

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ:

- *Дүрэм батлах тухай*
- *Монголын бүх ард түмний спартакиад зохион байгуулах тухай*

Улсын Их Хурлын Тамгын газар

Улаанбаатар хот

2003 он



ТӨРИЙН МЭДЭЭЛЭЛ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН АЛБАН МЭДЭЭЛЭЛ

Улаанбаатар хот

2003 оны наймдугаар сарын 27

№ 32 (317)

Гарчиг

Нэг. МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

489.	Довдонгийн Дашжамцад Монгол Улсын гавьяат дасгалжуулагч цол хүртээх тухай	Дугаар 141	789
490.	Хилийн цэргийн зарим ажилтныг одон, медалиар шагнах тухай	Дугаар 142	790
491.	Кристиан Освальдыг "Найрамдал" медалиар шагнах тухай	Дугаар 143	796
492.	Элчин сайдыг эгүүлэн татах, томилох тухай	Дугаар 145	796
493.	Элчин сайдыг эгүүлэн татах, томилох тухай	Дугаар 146	796

Хоёр. МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

494.	Дүрэм батлах тухай	Дугаар 164	796
495.	Монголын бүх ард түмний спартакиад зохион байгуулах тухай	Дугаар 167	804

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2003 оны 7 дугаар сарын 17-ны өдөр

Дугаар 141

Улаанбаатар хот

Довдонгийн Дашжамцад Монгол Улсын гавьяат дасгалжуулагч цол хүртээх тухай

Биеийн тамир, спортын хувь нэмрийг нь үнэлж Хилийн цэргийн байгууллагад олон жил үр бүтээлтэй "Хилчин" бөхийн клубийн захирал, ажиллаж үндэсний бөх, самбо, жудо, ахлах дасгалжуулагч Довдонгийн барилдаанаар баг, тамирчдаа Дашжамцад Монгол Улсын гавьяат дасгалжуулан дэлхий, тив, олон улсын дасгалжуулагч цол хүртээсүгэй.

болон, улсын аварга шалгаруулах тэмцээн, үндэсний их баяр наадамд удаа дараа амжилттай оролцуулж зэрэг, цолтой тамирчид бэлтгэх, бөхийн спортыг хөгжүүлэхэд оруулж байгаа

МОНГОЛ УЛСЫН

ЕРӨНХИЙЛӨГЧ Н.БАГАБАНДИ



МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2003 оны 7 дугаар сарын 17-ны өдөр

Дугаар 142

Улаанбаатар хот

Хилийн цэргийн зарим ажилтныг одон, медалиар шагнах тухай

Хил хамгаалах албанд олон жил үр бүтээлтэй ажиллаж байгаа дор дурдсан хүмүүсийг одон, медалиар шагнасуугай.

СҮХБААТАРЫН ОДОНГООР:

- | | |
|-----------------|---|
| 1. Шавийн Арвай | -Хилийн цэргийн дээд сургуулийн эрдэм шинжилгээний тэргүүлэх ажилтан, дэслэгч генерал |
|-----------------|---|

ЦЭРГИЙН ГАВЬЯАНЫ УЛААН ТУГИЙН ОДОНГООР:

- | | | | |
|--------------------------|--|----------------------------|--|
| 1. Баярхүүгийн Бямбажав | -Хилийн цэргийн 0243 дугаар ангийн захирагч, хурандаа | Дашдэлэг | сургуулийн тэнхмийн эрхлэгч, хурандаа |
| 2. Дондовын Ганбаатар | -Хил хамгаалах ерөнхий газрын техникийн газрын дарга, хурандаа | 6. Шанжмятавын Доржбал | -Хилийн цэргийн дээд сургуулийн тэнхмийн эрхлэгч, хурандаа |
| 3. Дагдангийн Ганжууржав | -Хилийн цэргийн 0164 дүгээр ангийн захирагч, хурандаа | 7. Даваанамсалын Доржпалам | -Хилийн цэргийн 0253 дугаар ангийн захирагч, хурандаа |
| 4. Долгорын Гончиг | -Хилийн цэргийн 0288 дугаар ангийн захирагч, хурандаа | 8. Сүхрагчаагийн Жалбуу | -Хилийн цэргийн 0311 дүгээр ангийн хилийн албаны дарга, хошууч |
| 5. Чинбатын | -Хилийн цэргийн дээд | 9. Жамсрангийн Чойнямбуу | -Хилийн цэргийн 0286 дугаар ангийн захирагч, хурандаа |

ХӨДӨЛМӨРИЙН ГАВЬЯАНЫ УЛААН ТУГИЙН ОДОНГООР:

- | | | | |
|-------------------------|--------------------------------|-----------|--|
| 1. Дашбалбарын Базарсад | -Монгол Улсын Их Хурлын гишүүн | Сэнгэдорж | дугаар ангийн гагнуурчин, ахлах ахлагч |
| 2. Банвайжилын | -Хилийн цэргийн 0253 | | |

ЦЭРГИЙН ГАВЬЯАНЫ ОДОНГООР:

- | | | | |
|---------------------------|--|-------------------------|---|
| 1. Төмөрбаатарын Алдар | -Буянт-Ухаа дахь хилийн шалган нэвтрүүлэх боомтын дарга, хурандаа | Борчулуун | дүгээр ангийн холбооны ерөнхий инженер, дэд хурандаа |
| 2. Ширнэнгийн Баатархүү | -Хилийн цэргийн 0257 дугаар ангийн санхүү, бүртгэлийн албаны дарга, дэд хурандаа | 8. Бямбажавын Буянжав | -Хил хамгаалах ерөнхий газрын Тамгын хэлтсийн дарга, хурандаа |
| 3. Дугаржавын Батцэнгэл | -Хилийн цэргийн 0108 дугаар ангийн захирагч, хурандаа | 9. Онхүүгийн Буяндэлгэр | -Хилийн цэргийн 0101 дүгээр ангийн захирал, хүний нөөцийн тасгийн дарга, дэд хурандаа |
| 4. Дамбын Баттулга | -Хилийн цэргийн дуу, бүжгийн чуулгын хөгжимчин, ахлах ахлагч | 10. Баатарын Ганбат | -Хилийн цэргийн 0146 дугаар ангийн штабын дарга, дэд хурандаа |
| 5. Бадамын Бат-Эрдэнэ | -Хилийн цэргийн дээд сургуулийн хилийн албаны тэнхмийн дарга, хурандаа | 11. Доржийн Ганболд | -Хилийн цэргийн 0306 дугаар ангийн захирагч, хурандаа |
| 6. Балжиннямын Баярсайхан | -Хилийн цэргийн 0129 дүгээр ангийн штабын дарга, дэд хурандаа | 12. Пүрэвийн Даш | Хил хамгаалах ерөнхий газрын дэд дарга бөгөөд штабын дарга, хошууч генерал |
| 7. Мажигжавын | -Хилийн цэргийн 0151 | | |

- | | | | |
|-------------------------------------|--|----------------------------------|--|
| 13. Гуржавын
Дурсгалжав | -Хил хамгаалах ерөнхий газрын 0168 дугаар ангийн хил хамгаалалт бэлэн байдлын офицер, дэд хурандаа | 25. Доохүүгийн
Оюунболд | -Хилийн цэргийн 0108 дугаар ангийн заставын дарга, дэд хурандаа |
| 14. Мянгаржавын
Заяабаатар | -Хилийн цэргийн 0184 дүгээр ангийн захирагч, хурандаа | 26. Цэвэлсүрэнгийн
Сангарачаа | -Хил хамгаалах ерөнхий газрын штабын хэлтсийн дарга, хурандаа |
| 15. Дамбийсанцэргийн
Лхагвасүрэн | -Хилийн цэргийн 0164 дүгээр ангийн захирагчийн орлогч, ерөнхий инженер, дэд хурандаа | 27. Шаравын
Сүхбаатар | -Хилийн цэргийн 0130 дугаар ангийн хүнсний албаны дарга, хошууч |
| 16. Дэлэгийн
Мөнхчулуун | -Буянт-Ухаа дахь хилийн шалган нэвтрүүлэх боомтын захирагчийн орлогч, штабын дарга бөгөөд шалган нэвтрүүлэх албаны дарга, дэд хурандаа | 28. Дарьзавын
Сүхтөмөр | -Хилийн цэргийн 0252 дугаар ангийн уст цэгийн бүлгийн дарга, хошууч |
| 17. Жамцын
Мэд | -Хил хамгаалах ерөнхий газрын штабын холбоо, мэдээллийн хэлтсийн ашиглалтын инженер, дэд хурандаа | 29. Цэрэндоржийн
Төмөр | -Хилийн цэргийн 0131 дүгээр ангийн захирагч, хурандаа |
| 18. Дайрийн
Мянгаржав | -Хилийн цэргийн 0146 дугаар ангийн техник ангийн дарга, хошууч | 30. Магийн
Хүрэл | -Хилийн цэргийн 0168 дугаар ангийн жолооч, ахлах ахлагч |
| 19. Дашбалжирын
Мянгаржав | -Хилийн цэргийн 0243 дугаар ангийн зэвсгийн албаны ахлах офицер, хошууч | 31. Тогнингийн
Хүрэлбаатар | -Хилийн цэргийн 0253 дугаар ангийн жолооч, ахлах ахлагч |
| 20. Раднаагийн
Наадамхүү | -Хилийн цэргийн 0129 дүгээр ангийн хилийн албаны тасгийн дарга, дэд хурандаа | 32. Жанцансамбуулын
Цэрэндорж | -Хил хамгаалах ерөнхий газрын ар тал, инженер техникийн газрын албаны дарга, ерөнхий инженер, хурандаа |
| 21. Норовын
Наранжамц | -Хилийн цэргийн дээд сургуулийн захирал, хурандаа | 33. Дашийн
Цэрэнпил | -Хилийн цэргийн 0119 дүгээр ангийн штабын дарга, хурандаа |
| 22. Жамбалын
Нацагдорж | -Хилийн цэргийн 0252 дугаар ангийн захирагчийн орлогч, штабын дарга, дэд хурандаа | 34. Ядамсүрэнгийн
Шүрэнчулуун | -Хил хамгаалах ерөнхий газрын ар тал, инженер техникийн газрын хүн эмнэлгийн албаны дарга, хурандаа |
| 23. Үрчигийн
Нацагдорж | -Хилийн цэргийн 0245 дугаар ангийн ар талын дарга, дэд хурандаа | 35. Жамбын
Шаравнямбуу | -Хилийн цэргийн 0277 дугаар ангийн ёс суртахуун, сэтгэл зүйн хангалтын дарга, дэд хурандаа |
| 24. Адышаабазарын
Нямдорж | -Хил хамгаалах ерөнхий газрын хилийн тагнуулын | 36. Тарвийн
Энхбат | -Хилийн цэргийн 0245 дугаар ангийн хилийн албаны офицер, хошууч |
| | | 37. Дожгочоогийн
Энхтөр | -Хилийн цэргийн 0108 дугаар ангийн хилийн албаны ахлах офицер, дэд хурандаа |

"АЛТАН ГАДАС" ОДОНГООР:

- | | | | |
|---------------------------|--------------------------------|-------|-----------------------------------|
| 1. Халидолдагийн
Жекей | -Монгол Улсын Их Хурлын гишүүн | Манал | бүжгийн чуулгын найрал дууны багш |
| 2. Галсангийн | -Хилийн цэргийн дуу, | | |



ЦЭРГИЙН ХҮНДЭТ МЕДАЛИАР:

- | | | | |
|-------------------------------|---|---------------------------------|--|
| 1. Самдаагийн
Баасансүрэн | -Хилийн цэргийн 0168
дугаар ангийн ёс суртахуун,
сэтгэл зүйн хангалтын
дарга, дэд хурандаа | 14. Хоовгын
Батчулуун | -Хилийн цэргийн 0131
дүгээр ангийн хилийн
албаны уулзалтын ахлах
офицер, хошууч |
| 2. Дэмбэрэлийн
Баатар | -Хилийн цэргийн 0285
дугаар ангийн хил
хамгаалалтын ахлах
офицер, хошууч | 15. Бөндгөөгийн
Баярбат | -Хилийн цэргийн 0245
дугаар ангийн штабын
дарга, дэд хурандаа |
| 3. Дашхүүгийн
Базар | -Хилийн цэргийн 0129
дүгээр ангийн барилга, орон
сууцны албаны дарга, хошууч | 16. Чадраабалын
Баярмагнай | -Хилийн цэргийн 0214
дүгээр ангийн техникийн
албаны дарга, дэслэгч |
| 4. Батчулууны
Батбаяр | -Хилийн цэргийн 0130
дугаар ангийн захирагч,
хурандаа | 17. Хандсүрэнгийн
Баярсайхан | -Хилийн цэргийн 0257
дугаар ангийн ёс суртахуун,
соёл хүмүүжлийн албаны
дарга, дэд хурандаа |
| 5. Гэндэнгийн
Батбаяр | -Хилийн цэргийн 0243
дугаар ангийн Цөхийн
заставын дарга, хошууч | 18. Цэрэнгийн
Болд | -Хилийн цэргийн 0184
дүгээр ангийн хувцас,
шатахууны албаны дарга,
хошууч |
| 6. Чимэднамжилын
Батдэлгэр | -Хил хамгаалах ерөнхий
газрын төсвийн
мэргэжилтэн, нягтлан
бодогч, дэд хурандаа | 19. Балжиннямын
Болдбаатар | -Хилийн цэргийн 0198
дугаар ангийн штабын
дарга, дэд хурандаа |
| 7. Гарамжавын
Батнасан | -Хил хамгаалах ерөнхий
газрын дүн шинжилгээний
офицер, дэд хурандаа | 20. Шарын
Борчулуун | -Хилийн цэргийн 0146
дугаар ангийн жолооч,
ахлах ахлагч |
| 8. Цэндийн
Батсайхан | -Хил хамгаалах ерөнхий
газрын эрүүл ахуй, халдвар
судлалын хяналтын албаны
дарга, дэд хурандаа | 21. Рэнцэнгийн
Буд | -Хил хамгаалах ерөнхий
газрын мал аж ахуйн албаны
мал зүйч, малын их эмч, дэд
хурандаа |
| 9. Лхамжавын
Батсүх | -Хилийн цэргийн 0245
дугаар ангийн захирагч,
хурандаа | 22. Пандийн
Буянхүү | -Хил хамгаалах ерөнхий
газрын хяналт шинжилгээ
үнэлгээний ахлах ажилтан,
хурандаа |
| 10. Зундуйн
Баттөмөр | -Хилийн цэргийн 0164
дүгээр ангийн хэвлэлийн
төлөөлөгч, дэд хурандаа | 23. Нокоогийн
Галбадрах | -Хилийн цэргийн 0311
дүгээр ангийн захирагч,
хурандаа |
| 11. Алтангэрэлийн
Баттулга | -Хилийн цэргийн 0132
дугаар ангийн ёс суртахуун,
сэтгэл зүйн хангалтын
албаны дарга, хошууч | 24. Сүрэнгийн
Ганбаяр | -Хилийн цэргийн 0131
дүгээр ангийн холбоо,
мэдээлийн албаны дарга,
дэд хурандаа |
| 12. Жийшаагийн
Баттулга | -Хилийн цэргийн 0108
дугаар ангийн гагнуурчин,
ахлах ахлагч | 25. Агвааны
Ганболд | -Хилийн цэргийн 0108
дугаар ангийн инженер,
дохиоллын офицер, хошууч |
| 13. Пунцагдоржийн
Баттулга | -Хилийн цэргийн 0166
дугаар ангийн 4 дүгээр
заставын дарга, хошууч | 26. Жигжидийн
Ганболд | -Хилийн цэргийн 0168
дугаар ангийн техник ангийн |

	дарга, хошууч		заставын дарга, дэд хурандаа
27. Тууганы Ганболд	-Хилийн цэргийн 0130 дугаар ангийн жолооч, ахлах ахлагч	40. Чойсүрэнгийн Долгор	-Хилийн цэргийн 0253 дугаар ангийн музейн фондын эрхлэгч, ахлах ахлагч
28. Цэрэнпунцагийн Гансүх	-Хилийн цэргийн 0151 дүгээр ангийн холбооны суурин зангилааны дарга, дэд хурандаа	41. Дашдондогийн Жанчивсүрэн	-Хилийн цэргийн 0101 дүгээр ангийн шифрийн офицер, хошууч
29. Рагчаагийн Гантөмөр	-Хилийн цэргийн 0311 дүгээр ангийн штабын дарга, дэд хурандаа	42. Батаагийн Жанцан-хорлоо	-Төрийн тусгай албан хаагчдын нэгдсэн эмнэлгийн их эмч, дэд хурандаа
30. Дэнсмаагийн Гонгорсүрэн	-Хил хамгаалах ерөнхий газрын нисэх инженерийн техник хэрэгслэлийн офицер, дэд хурандаа	43. Ганжуурын Жаргалсайхан	-Хилийн цэргийн 0108 дугаар ангийн сургалт хүмүүжлийн албаны дарга, хошууч
31. Жамцын Гончиг	-Хилийн цэргийн 0184 дүгээр ангийн аж ахуйн дарга, ахлах ахлагч	44. Далхаасүрэнгийн Жаргалсайхан	Хилийн цэргийн 0146 дугаар ангийн жолооч, ахлах ахлагч
32. Лхагвасүрэнгийн Даваасамбуу	-Хил хамгаалах ерөнхий газрын санхүү бүртгэлийн хэлтсийн дарга, ерөнхий нягтлан бодогч, хурандаа	45. Нямсүрэнгийн Жаргалсайхан	-Хилийн цэргийн 0146 дугаар ангийн захирагч, хурандаа
33. Цэрэнжидийн Дагвадорж	-Хилийн цэргийн 0108 дугаар ангийн зэвсгийн мастер, ахлах ахлагч	46. Дашдаваагийн Жаргалсайхан	-Хилийн цэргийн 0218 дугаар ангийн жолооч, ахлах ахлагч
34. Ванчигнямын Дамдинсүрэн	-Хилийн цэргийн 0277 дугаар ангийн дарга, хурандаа	47. Товуудагвын Жаргалсайхан	-Хилийн цэргийн 0101 дүгээр ангийн төмөр замын шалган нэвтрүүлэх боомтын дарга, дэд хурандаа
35. Дашцэрэнгийн Дашдаваа	-Хил хамгаалах ерөнхий газрын сургалт хүмүүжлийн газрын дарга, хурандаа	48. Цогбалын Жаргалсайхан	-Хилийн цэргийн 0132 дугаар ангийн ар тал, техникийн албаны дарга, хошууч
36. Сэрээтэрийн Дашдэмбэрэл	-Хилийн цэргийн 0146 дугаар ангийн заставын дарга, дэд хурандаа	49. Цэрэндоржийн Жаргалсайхан	-Хилийн цэргийн 0151 дүгээр ангийн жолооч, ахлагч
37. Чагцалын Дашням	-Хил хамгаалах ерөнхий газрын Тамгын хэлтсийн нууцын дарга, орон тооны ахлах офицер, дэд хурандаа	50. Галгээгийн Загд	-Хилийн цэргийн 0257 дугаар ангийн заставын дарга, хошууч
38. Таванжингийн Дашцэрэн	-Хилийн цэргийн 0166 дугаар сургалт хүмүүжлийн албаны дарга, дэд хурандаа	51. Сэрээтэрийн Зэсэндүйчир	-Хилийн цэргийн 0214 дүгээр ангийн сургалт хүмүүжлийн албаны дарга, дэд хурандаа
39. Гүндсамбуугийн Даш-Эрдэнэ	-Хилийн цэргийн 0243 дугаар ангийн Номтын		

52. Будбазарын Ловуу-Игнэн	-Хилийн цэргийн 0285 дугаар ангийн захирагч, хурандаа	65. Идээгийн Нямсүрэн	дарга, дэд хурандаа -Хилийн цэргийн 0101 дүгээр ангийн жагсаалын дарга, ахлах ахлагч
53. Аминдаваагийн Лхагвасүрэн	-Хил хамгаалах ерөнхий газрын хил хамгаалалтын газрын орлогч, хилийн шалган нэвтрүүлэх хэлтсийн дарга, хурандаа	66. Түмэндэлгэрийн Нямсүрэн	-Хилийн цэргийн 0129 дүгээр ангийн техник ангийн дарга, дэд хурандаа
54. Балжидын Лхагвасүрэн	-Хилийн цэргийн 0108 дугаар ангийн зэвсэг техникийн ахлах офицер, хошууч	67. Базаррагчаагийн Одгэрэл	-Хилийн цэргийн 0253 дугаар ангийн штабын дарга, дэд хурандаа
55. Базарын Мандах	-Хилийн цэргийн 0252 дугаар ангийн хүн эмнэлгийн бага эмч, хошууч	68. Төмөрбаатарын Отгонбаяр	-Хилийн цэргийн 0287 дугаар ангийн захирагчийн орлогч, тагнуулын тасгийн дарга, дэд хурандаа
56. Дашбалын Мөнхбат	-Хил хамгаалах ерөнхий газрын хил хамгаалалтын газрын шалган нэвтрүүлэх албаны дарга, дэд хурандаа	69. Баатарцогтын Отгонжаргал	-Хилийн цэргийн 0287 дугаар ангийн сургалт хүмүүжлийн албаны дарга, хошууч
57. Содномцэрэнгийн Мөнхцэцэг	-Хилийн цэргийн 0168 дугаар ангийн санхүү бүртгэлийн албаны дарга, дэд хурандаа	70. Самбуугийн Оюунчимэг	-Хилийн цэргийн 0253 дугаар ангийн бичээч-бичиг хэргийн эрхлэгч, ахлах ахлагч
58. Цэдэндоржийн Мөнхцэцэг	-Хилийн цэргийн 0108 дугаар ангийн хилчин- шалгагч, ахлах ахлагч	71. Думжавын Пүрэв	-Хилийн цэргийн 0166 дугаар ангийн техник ангийн дарга, хошууч
59. Дүгэрсүрэнгийн Наваансамдан	-Хилийн цэргийн 0164 дүгээр ангийн жолооч, ахлах ахлагч	72. Санжаагийн Раднаабазар	-Хилийн цэргийн 0151 дүгээр ангийн ар талын орлогч, дэд хурандаа
60. Дашдаваагийн Намхайдагва	-Хилийн цэргийн 0151 дүгээр ангийн автын салааны захирагч, ахмад	73. Баатарсүрэнгийн Ренчинбямба	-Хилийн цэргийн 0287 дугаар ангийн автын механикч, жолооч, ахлах ахлагч
61. Гантөмөрийн Наранцэцэг	-Хилийн цэргийн 0146 дугаар ангийн бичиг баримтын шалгагч, ахлах ахлагч	74. Гомбосүрэнгийн Сайнхүү	-Хилийн цэргийн 0151 дүгээр ангийн зэвсгийн албаны дарга, хошууч
62. Баатарын Нармандах	-Хил хамгаалах ерөнхий газрын даргын туслах, хошууч	75. Батжаргалын Сарантуяа	-Хилийн цэргийн 0151 дүгээр ангийн штабын дарга, дэд хурандаа
63. Лхагвын Нямжав	-Хилийн цэргийн 0253 дугаар ангийн захиргаа, хүний нөөцийн тасгийн дарга, дэд хурандаа	76. Санжмятавын Сарантуяа	-Хилийн цэргийн 0218 дугаар ангийн архив нууцын эрхлэгч, ахлах ахлагч
64. Доржсүрэнгийн Нямсүрэн	Хилийн цэргийн 0168 дугаар ангийн штабын	77. Ренчингийн Сонинбаяр	-Хилийн цэргийн 0146 дугаар ангийн жолооч, ахлах ахлагч
		78. Дагвын Сэнгэдорж	-Хилийн цэргийн 0151 дүгээр ангийн ухуулга,

79. Цэдэвийн Сэргэлэн	сурталчилгаа, хүмүүжил хариуцсан офицер, хошууч -Хилийн цэргийн 0132 дугаар ангийн захирагч, хурандаа	87. Жаалын Цогбадрах	-Хилийн цэргийн 0166 дугаар ангийн ар тал, техникийн албаны дарга, дэд хурандаа
80. Самбуугийн Сэрдамба	-Хилийн цэргийн 0198 дугаар ангийн жолооч, ахлах ахлагч	88. Энэбишийн Цогтгэрэл	-Хилийн цэргийн 0119 дүгээр ангийн цахилгаанчин, ахлах ахлагч
81. Чогсомжавын Төрнэмэх	-Хилийн цэргийн 0164 дүгээр ангийн жолооч, ахлах ахлагч	89. Жанчидоржийн Цэрэндулам	-Хилийн цэргийн 0151 дүгээр ангийн хувцасны албаны дарга, хошууч
82. Баажийн Тунгалаг	-Хилийн цэргийн 0288 дугаар ангийн санхүү бүртгэлийн албаны дарга, ерөнхий нягтлан бодогч, дэд хурандаа	90. Гомбожавын Чимэдбат	-Хилийн цэргийн 0253 дугаар ангийн дизель засвар бүлгийн дарга, хошууч
83. Дамбын Түдэвдорж	-Хил хамгаалах ерөнхий газрын орон сууцны төлөвлөлт, түлш хангалт, худаг усны инженер, дэд хурандаа	91. Жамъянгийн Чулуунхүү	-Хилийн цэргийн 0218 дугаар ангийн ахлах офицер, дэд хурандаа
84. Базарзарын Тэрбиш	-Хил хамгаалах ерөнхий газрын хилийн тагнуулын албаны шифрийн албаны офицер, дэд хурандаа	92. Норовын Шатар	-Хилийн цэргийн 0164 дүгээр ангийн цэргийн тоо бүртгэлийн офицер, хошууч
85. Юнрэндоржийн Хадхүү	-Хил хамгаалах ерөнхий газрын мэдээлэл сүлжээний инженер, дэд хурандаа	93. Доржийн Энхбаатар	-Хилийн цэргийн 0166 дугаар ангийн бэлтгэл заставын дарга, хошууч
86. Цэрэндоржийн Хишигбаатар	-Хилийн цэргийн 0252 дугаар ангийн захирагчийн орлогч, ерөнхий инженер, дэд хурандаа	94. Цэрэндашийн Энхбат	-Хилийн цэргийн дээд сургуулийн ахлах багш, дэд хурандаа
		95. Намжилсүрэнгийн Энхтайван	-Хилийн цэргийн 0151 дүгээр ангийн зэвсэг техникийн албаны орлогч, дэд хурандаа
		96. Данзангийн Эрдэнэбат	-Хилийн цэргийн 0168 дугаар ангийн захиргаа, хүний нөөцийн тасгийн дарга, дэд хурандаа

ХӨДӨЛМӨРИЙН ХҮНДЭТ МЕДАЛИАР:

1. Аюушийн Алтанцэцэг	-Хилийн цэргийн 0130 дугаар ангийн бичээч	4. Дэмбэрэлийн Сумъяа	-Хилийн цэргийн 0184 дүгээр ангийн эмийн санч
2. Цэвэгжавын Батбулгаа	-Хилийн цэргийн 0130 дугаар ангийн хувцас, барилга орон сууц болон хүнсний нярав	5. Цэвээний Хоролсүрэн	-Хил хамгаалах ерөнхий газрын хөрөнгө оруулалт, барилгын албаны ахлах нягтлан бодогч
3. Жамъянсүрэнгийн Даринчулуун	-Хилийн цэргийн 0277 дугаар ангийн хувцас, хүнсний албаны дарга, ахлах ахлагч		

**МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙЛӨГЧ**

Н.БАГАБАНДИ



МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2003 оны 7 дугаар сарын 17-ны өдөр

Дугаар 143

Улаанбаатар хот

Кристиан Освальдыг "Найрамдал" медалиар шагнах тухай

Монгол Улс, ХБНГУ-ын байгаль орчны салбарын хамтын ажиллагааг хөгжүүлэх, монгол орны байгаль хамгаалах, тахь нутагшуулах үйлсэд оруулж байгаа хувь нэмрийг нь үнэлж ХБНГУ-ын Кристиан Освальдын сангийн ерөнхийлөгч Кристиан

Освальдыг "Найрамдал" медалиар шагнаасугай.

МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙЛӨГЧ

Н.БАГАБАНДИ

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2003 оны 7 дугаар сарын 21-ний өдөр

Дугаар 145

Улаанбаатар хот

Элчин сайдыг эгүүлэн татах, томилох тухай

Монгол Улсын Үндсэн хуулийн гучин гуравдугаар зүйлийн 1 дэх хэсгийн 5, Ерөнхийлөгчийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 3, Дипломат албаны тухай хуулийн 16 дугаар зүйлийн 1 дэх хэсгийг баримтлан ЗАРЛИГ болгох нь:

Булгаагийн Алтангэрэлийг эгүүлэн татсугай.

2. Монгол Улсаас Туркменистан Улсад суух Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайдаар Паньджунайн Халиуныг тохоон томилсугай.

МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙЛӨГЧ

Н.БАГАБАНДИ

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2003 оны 7 дугаар сарын 21-ний өдөр

Дугаар 146

Улаанбаатар хот

Элчин сайдыг эгүүлэн татах, томилох тухай

Монгол Улсын Үндсэн хуулийн гучин гуравдугаар зүйлийн 1 дэх хэсгийн 5, Ерөнхийлөгчийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 3, Дипломат албаны тухай хуулийн 16 дугаар зүйлийн 1 дэх хэсгийг баримтлан ЗАРЛИГ болгох нь:

татсугай.

2. Монгол Улсаас Бүгд Найрамдах Узбекистан Улсад суух Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайдаар Паньджунайн Халиуныг тохоон томилсугай.

МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙЛӨГЧ

Н.БАГАБАНДИ

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2003 оны 7 дугаар сарын 4-ний өдөр

Дугаар 164

Улаанбаатар хот

Дүрэм батлах тухай

Үндэсний их баяр наадмын тухай хуулийн 11 дүгээр зүйлийг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

2. Батлагдсан дүрмүүдийг хэрэгжүүлж, биелэлтэд нь хяналт тавьж ажиллахыг Үндэсний их баяр наадмыг зохион байгуулах хороо (П.НЯМДАВАА)-нд даалгасугай.

1. "Үндэсний их баяр наадмыг зохион байгуулах хорооны дүрэм"-ийг 1 дүгээр, "Үндэсний их баяр наадмын үндэсний бөхийн барилдааны дүрэм"-ийг 2 дугаар, "Үндэсний их баяр наадмын хурдан морины уралдааны дүрэм"-ийг 3 дугаар, "Үндэсний их баяр наадмын үндэсний сурын харвааны дүрэм"-ийг 4 дүгээр хавсралт ёсоор тус тус баталсугай.

МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ САЙД

Н.ЭНХБАЯР

ЭРҮҮЛ МЭНДИЙН
САЙД

П.НЯМДАВАА

ҮНДЭСНИЙ ИХ БАЯР НААДМЫГ ЗОХИОН БАЙГУУЛАХ ХОРООНЫ ДҮРЭМ

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Энэхүү дүрмийн зорилго нь Үндэсний их баяр наадмыг хууль, уламжлалт ёс заншилд тулгуурлан улс орон даяар тэмдэглэн өнгөрүүлэх ажлыг зохион байгуулах хорооны үйл ажиллагааг зохицуулахад оршино.

1.2. Үндэсний их баяр наадмыг зохион байгуулах хороо (цаашид "Хороо" гэх) нь үйл ажиллагаандаа Үндэсний их баяр наадмын тухай хууль, энэхүү дүрэм, хууль тогтоомжийн бусад актыг мөрдлөг болгоно.

1.3. Хороо нь албан бичгийн хэвлэмэл хуудас, тэмдэг хэрэглэнэ.

Хоёр. Хорооны удирдлага, зохион байгуулалт

2.1. Хороо нь орон тооны бус байх бөгөөд түүний бүрэлдэхүүнийг Монгол Улсын Засгийн газар батална.

2.2. Хорооны үйл ажиллагааны үндсэн хэлбэр нь хуралдаан байх бөгөөд нийт гишүүдийн гуравны хоёр нь оролцсон тохиолдолд хүчинтэйд тооцогдоно. Хуралдаанаар хэлэлцсэн асуудлыг олонхийн саналаар шийдвэрлэж тогтоол гаргана. Тогтоолд Хорооны дарга болон нарийн бичгийн дарга гарын үсэг зурна. Хуралдааны явцын тухай тэмдэглэл хөтөлнө. Тэмдэглэлд хорооны нарийн бичгийн дарга, тэмдэглэл хөтөлсөн албан тушаалтан гарын үсэг зурна.

2.3. Хорооны дарга нь хуралдааны дэгийг тогтоож, хуралдааныг удирдах бөгөөд түүний эзгүйд дэд дарга бүрэн эрхийг нь хэрэгжүүлнэ.

2.4. Хорооноос хорооны гишүүнээр ахлуулсан салбар хороодыг байгуулан ажиллуулна.

2.5. Салбар хороо нь Хорооноос өгсөн үүрэг, даалгавар, батлагдсан төлөвлөгөө, төсвийн хүрээнд үйл ажиллагаагаа явуулна.

2.6. Хорооны ажлын албаны үүргийг

нийслэлийн Засаг даргын Тамгын газар гүйцэтгэнэ.

Гурав. Хорооны бүрэн эрх

3.1. Хороо нь дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

3.1.1. Үндэсний их баяр наадмыг улс орон даяар тэмдэглэн өнгөрүүлэх ажлыг хариуцан наадмын нээлт, хаалт, төрийн ёслолын арга хэмжээг холбогдох хууль, дүрэм, журмын дагуу зохион байгуулах;

3.1.2. Үндэсний их баяр наадмын тухай хуулийн 12 дугаар зүйлд заасан бүрэн эрхийг хэрэгжүүлж, Монгол Улсын Засгийн газрын өмнө ажлаа хариуцан тайлагнах;

3.1.3. Хорооны бүрэлдэхүүн Үндэсний их баяр наадмын тухай хуулийг хэрэгжүүлэхээр Засгийн газраас батлах шийдвэрийн төсөл боловсруулах;

3.1.4. өөрийн болон салбар хорооны үйл ажиллагааны төлөвлөгөө, салбар хороодын бүрэлдэхүүнийг хэлэлцэн баталж, үйл ажиллагааг нь удирдан чиглүүлж тайланг хэлэлцэх;

3.1.5. Улсын баяр наадмыг тэмдэглэн өнгөрүүлэхэд шаардагдах төсвийн төслийг хуульд заасан хугацаанд боловсруулан батлуулж, батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах, шаардлагатай бол төсвийн тодорхой хэсгийг салбар хороодод хуваарилж, зарцуулалтад нь хяналт тавих;

3.1.6. салбар хороодоос баяр наадмыг тэмдэглэн өнгөрүүлэх талаар зохион байгуулсан ажил, санхүүгийн тайланг баяр наадам дууссанаас хойш ажлын 5 өдөрт багтаан авч нэгтгэн үнэлэлт, дүгнэлт өгөх;

3.1.7. аймаг, сумын баяр наадмыг тэмдэглэн өнгөрүүлэх нийтлэг журмыг батлан мөрдүүлж, хэрэгжилтэд нь хяналт тавих;

3.1.8. баяр наадамд оролцож байгаа бөх,

уяач, харваач болон бусад холбогдох этгээдээс гаргасан гомдол, саналыг өөрийн эрх хэмжээний хүрээнд шийдвэрлэх;

3.1.9. Баяр наадмын билэгдлийн тэмдэг, цол, шагналын үнэмлэх зэргийн загварыг батална.

3.2. Хороо нь дараахь асуудлаар төрийн холбогдох байгууллагад санал гаргах эрхтэй:

3.2.1 Улсын баяр наадмыг тэмдэглэн өнгөрүүлэх төрийн ёслолын арга хэмжээний журам болон хөтөлбөрийн төсөл;

3.2.2 Улсын баяр наадмыг тэмдэглэн өнгөрүүлэх газрыг тогтоох;

3.2.3 Бөх, харваач, уяач, хурдан морины уралдааны бай шагналын хэмжээг тогтоох.

Дөрөв. Бусад зүйл

4.1. Баяр наадмыг тэмдэглэн өнгөрүүлэхэд идэвхи зүтгэлтэй, сайн ажилласан хүмүүсийг Хорооноос мөнгөн шагналаар шагнах, бусад хэлбэрээр урамшуулах болон шагнуулах тухай саналаа холбогдох байгууллага, албан тушаалтанд тавина.

4.2. Хороо болон салбар хороо нь Үндэсний их баяр наадмын тухай хууль болон холбогдох дүрмийг зөрчсөн бөх, уяач, харваачдад Үндэсний их баяр наадмын тухай хуулийн 14 дүгээр зүйлд заасан хариуцлагыг ногдуулна.

4.3. Хороо болон салбар хороодоос өгсөн үүрэг, даалгаврыг хангалтгүй биелүүлсэн гишүүн, албан тушаалтанд арга хэмжээ авахуулахаар холбогдох байгууллага, албан тушаалтанд саналаа тавина.

Засгийн газрын 2003 оны 164 дүгээр тогтоолын 2 дугаар хавсралт

ҮНДЭСНИЙ ИХ БАЯР НААДМЫН ҮНДЭСНИЙ БӨХИЙН БАРИЛДААНЫ ДҮРЭМ

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Үндэсний их баяр наадмын үндэсний бөхийн барилдааныг зохион байгуулахад Үндэсний их баяр наадмын тухай хууль болон энэхүү дүрмийг мөрдөнө.

1.2. Үндэсний их баяр наадмын үндэсний бөхийн барилдааныг зохион байгуулахдаа бөхийн гараа, бөхийг цоллох ёсон, барилдаан болон барилдааны дараахь ёсон, жаяг дэгийн баг (хөлийн цэц, засуул, гарын даа, тайлбарлагч)-ийн гишүүд, бөхийн эрх, үүрэг, цээр болон энэ дүрэмд тусгаагүй барилдаантай холбогдох бусад асуудлыг Монголын үндэсний бөхийн холбооны цэцдийн зөвлөлөөс баталсан "Монголын үндэсний бөхийн барилдааны дүрэм", түүнийг хэрэгжүүлэх заавар, бөхийн эмсгөлийн шаардлагыг баримтална.

Хоёр. Бөхийн барилдааны салбар хороо

2.1. Улсын наадмын үндэсний бөхийн барилдааныг Бөхийн барилдааны салбар хороо (цаашид "салбар хороо" гэх) хариуцан зохион байгуулна.

2.2. Салбар хорооны бүрэлдэхүүнийг Үндэсний их баяр наадмыг зохион байгуулах хороо (цаашид "Хороо" гэх) батална.

Гурав. Бөхийг бүртгэх, эрэмбэлэх

3.1. Үндэсний их баяр наадамд барилдах бөхчүүдийг гарын даа нар баяр наадам болохоос 2 хоногийн өмнөх өдрийн 10.00 цагаас эхлэн бүртгэж баяр наадмын өмнөх өдрийн 18.00 цагт дуусгана.

3.2. Улсын баяр наадмын үндэсний бөхийн барилдаанд 18-аас дээш насны бөхийг барилдуулна.

3.3. Үндэсний их баяр наадамд барилдах бөх иргэний үнэмлэхтэйгээ ирж өөрийн биеэр бүртгүүлэх бөгөөд цолтой бөх нь заавал цолны үнэмлэхтэй байна.

3.4. Тогтоосон хугацаанд бүртгүүлээгүй бөхийг бүртгэл хаасны дараа нэмж бүртгэхгүй.

3.5. Бүртгүүлсэн бөхчүүдийн цол болон амжилтаар нь эрэмбэлсэн жагсаалтыг Монголын

Үндэсний бөхийн холбоо тус тус гаргах бөгөөд энэ жагсаалтад ороогүй бөхийг барилдуулахгүй.

3.6. Үндэсний их баяр наадмын тухай хууль батлагдахаас өмнө цол авсан бөхчүүдийг цолны уламжлалт эрэмбээр нь, 2003 онд цол хүртсэн бөхчүүдээс эхлэн үзүүлсэн амжилтаар нь дараахь үзүүлэлтээр эрэмбэлэн жагсаалтад оруулна:

3.6.1. ижил цолтой бөхчүүдээс тухайн цолны болзлоо олон биелүүлснийг, энэхүү нөхцөл ижил байвал доод давааг олон давсныг эхэнд нь эрэмбэлэх бөгөөд энэ жишгээр начин цолны даваа хүртэл тооцоход амжилт нь ижил байвал хэн түрүүлж одоогийн цолоо хүртсэн хугацаагаар, энэхүү нөхцөл мөн ижил байвал доод цолуудыг хүртсэн хугацааг тус тус харгалзаж эрэмбэлнэ;

3.6.2. нэг өдөр адил даваагаар ижил цол авсан бөхчүүдээс өмнөх цолоо түрүүлж авсан нь, энэхүү нөхцөл нь ижил буюу өмнө нь цолгүй байсан бол тулгаж барилдуулах жагсаалтад бичигдсэн дарааллаар эрэмбэлнэ. Ийнхүү эрэмбэ тогтоох боломжгүй бол шодож эрэмбийг тогтооно.

3.7. Үндэсний их баяр наадамд барилдах бөхчүүдийн эрэмбийн жагсаалтыг шат шатны баяр наадмыг зохион байгуулах бөхийн салбар хорооны дарга хянаж баталгаажуулна.

Дөрөв. Бөхийг тулгаж барилдуулах, амлах

4.1. Үндэсний их баяр наадмын бөхийн барилдааныг бөхчилсөн хэлбэрээр явуулна.

4.2. Үндэсний их баяр наадмын бөхийн барилдааны нэг, хоёр, дөрвийн даваанд бөхийн цолны эрэмбээр гаргасан жагсаалтын дагуу тулгаж, бусад даваанд цолны болон амжилтын эрэмбээр угтуул бөх нэр сонсон ам авч барилдана.

4.3. Ижил цолтой бөхчүүд энэ дүрмийн 3.6.1, 3.6.2-т заасны дагуу тогтоосон эрэмбээр ам авна.

4.4. Улсын баяр наадамд аймаг, цэрэг, сумын цолтой бөх ам авахгүй.

Тав. Барилдааны хугацаа

5.1. Бөхийн барилдааны үргэлжлэх үндсэн хугацааг дараахь байдлаар тогтооно:

5.1.1. нэг, хоёр, гурав, дөрвийн даваанд тус бүр 10 минут;

5.1.2. тав, зургаа, долоогийн даваанд тус бүр 15 минут;

5.1.3. найм, ес болон түүнээс дээш даваанд тус бүр 30 минут.

5.2. Барилдааны үндсэн хугацаа дуусахад хаялцаагүй бөхчүүдийн барилдааныг хөлийн цэц зогсоож, шодолт хийн, хожсон бөхийн сонгож авсан шахааны барьцыг түүний талаар бариулж барилдааныг үргэлжлүүлнэ. Барьц авсан бөх тогтоосон хугацаанд эс хаявал учраа бөхөд нь дээрх боломжийг олгоно. Энэ тохиолдолд эс хаялцвал дараагийн шахаа барьцаар бариулах замаар шахааны барьцын хувилбаруудыг дуустал барилдуулна.

5.3. Шахааны барьцнаас хаялцаагүй тохиолдолд дахин шодолт хийж, хожсон бөх нэг гараар учраа бөхийнхөө араар тойруулан зодогны алсын сүвээгээс, нөгөө гараараа шуудагдан барих барьцыг хөлийн цэц бариулж барилдааныг үргэлжлүүлнэ. Энэ барьцнаас эс хаялцвал учраа бөхөд нь дээрх боломжийг олгох замаар барилдааныг дуустал үргэлжлүүлнэ.

5.4. Сонгосон барьцтай барилдааныг 3 минутаас илүү үргэлжлүүлэхгүй бөгөөд үүнээс өмнө барьц тавилцвал дараагийн барьцыг бариулж барилдуулна.

5.5. Энэ дүрмийн 5.3-т заасан барьцыг Үндэсний их баяр наадмын шөвгийн дөрөвт үлдсэн бөхчүүдийн барилдаанд хэрэглэхгүй.

5.6. Тухайн дүйз барилдаан эхэлснээс хойш 10 минут өнгөрөхөд гарч ирээгүй бөхийг унасанд, нөгөө бөхийг давсанд тооцно.

Зургаа. Бөхөд цол, чимэг олгох

6.1. Үндэсний их баяр наадмын үндэсний бөхийн барилдаанд таваас дээш давж шөвгөрсөн бөхчүүдэд Үндэсний их баяр наадмын тухай хуульд заасан цолуудыг олгоно.

6.2. Улсын наадамд шөвгөрсөн, үзүүлсэн, түрүүлсэн улсын цолтой бөхчүүдэд дараахь чимгийг дэс дараалан олгоно:

6.2.1. Тав давсан бөхөд: есөх идэр, улам нэмэх, хурц шаламгай, уран мэхт, өрнөн дэлгэрэх, улам өрнөх, цог нэмэх, идэр шаламгай, хурдан гарамгай;

6.2.2. Зургаа давсан бөхөд: үнэн зоригт, цогт гарамгай, үлэмж дэлгэрэх, үнэн итгэлт, сөрүүл шаламгай, өнөд амгалант, чин хүчит, идэвхит итгэлт, бат өрөөлт;

6.2.3. Долоо давсан бөхөд: саруул сайжрах, хууринан шуугигч, өлзий бадрах, үлэмж хичээнгүй, онц бярадагч, бат нягт, чин зоригт, бахдам гарамгай, хичээнгүй нягт;

6.2.4. Найм давсан бөхөд: үлэмж бадрах, бууршгүй хүчит, тод сонин, баатар зоригт, бат өлзийт, тонж гарамгай, нэн дуурсгалт, харилтгүй жавхлантай, хэтэрхий хурц, өнөд түвшин;

6.2.5. Ес давсан бөхөд: баяр наадмын манлай, түмнээс төгөлдөр, улс даяар гайхамшигт, тод сонин үзэсгэлэнт, олныг баясуулагч, бүхнээ дуурсгалт, үнэхээр бишрэлт, өнөд баясгалант, уламжлан дуурсах;

6.2.6. Арав давсан бөхөд: хотлоорыг баясуулагч, харилгүй үзэсгэлэнт, үлэмж хэтэрхий, гонж гарамгай жавхлантай, аугаа хүчит бүхнээ сонсолонт.

6.3. Аймаг, цэргийн наадамд шөвгөрсөн, үзүүлсэн, түрүүлсэн аймаг, цэргийн цолтой бөхөд дараахь чимгүүдийг олгоно:

6.3.1. Тав давсан бөхөд: өрнөх,

өлзийт, зоригт;

6.3.2. Зургаа давсан бөхөд: цогт, хичээнгүй, хүчит, идэвхит;

6.3.3. Долоо, найм давсан бөхөд: хурц, бадрангүй, хичээлт, итгэлт, өрөөлт, харилтгүй, дуурсах, жавхлантай.

6.4. Сумын наадамд шөвгөрсөн, үзүүлсэн, түрүүлсэн цолтой бөхөд чимэг олгохгүй.

6.5. Үндэсний их баяр наадмаар 16 хүртэлх насны хүүхдийн барилдааныг тусад нь явуулж болох бөгөөд түрүүлсэн хүүхдэд шонхор, үзүүлсэн хүүхдэд шандас цол олгоно.

Долоо. Хариуцлага

7.1. Дараахь тохиолдолд бөхийг хөлийн цэцийн саналыг үндэслэн салбар хорооны шийдвэрээр тухайн барилдаанаас хасна:

7.1.1. үндэсний бөхийн барилдааны дүрмийн заалтыг зөрчсөн;

7.1.2. барилдааны явцад хөлийн цэц, засуулаас тавьсан шаардлагыг биелүүлээгүй;

7.1.3. нэгэнт ам авсан бөх амаа сольсон, өөрөөсөө хойно эрэмбэтэй бөхийг өмнөө ам авахыг зөвшөөрсөн буюу албадсан, тэрчлэн хэн нэг бөхийг амлан авахыг өөр бөхөд тулган шахсан;

7.1.4. шахээны барьц барих, бариулахаас татгалзсан болон уг барьцыг бариулах үед элэг бүс, шуудагны уяаг сулласан.

7.2. Хөлийн цэцийн шийдвэр гараагүй байхад засуулын гараас малгайгаа авах, туг тойрох зэргээр дүрмийн бус үйлдэл хийсэн бөхийн учраа бөхийг давсанд тооцож, зерчил гаргасан бөхийн давааны бай шагналыг хасах шийдвэрийг хөлийн цэцийн саналыг үндэслэн салбар хороо гаргана.

7.3. Хөлийн цэц болон засуулаас тавьсан

шаардлагыг үл хэрэгсэн удаа дараа хориотой буюу буруу барьц барих, гэмтээх барьц барих, гэмтээх хөдөлгөөн хийх зэрэг үйлдэл гаргасан бөхийг салбар хорооны шийдвэрээр барилдаанаас хасна.

7.4. Дор дурдсан зөрчил гаргасан бөхөд Хороо дараахь арга хэмжээ авна:

7.4.1. Наадамчин олон, баяр наадмаа үл хүндэтгэсэн, төрийн ёслол, зан уламжлалыг зөрчсөн үйлдэл хийсэн, учраа бөхөө санаатайгаар гэмтээсэн тохиолдолд тухайн бөхийн барилдах эрхийг 2 жил хүртэл хугацаагаар хасах,

7.4.2. Сэргээш хэрэглэсэн нь лабораторийн шинжилгээгээр тогтоогдсон бол уг бөхийн наадамд давсан давааг хүчингүй болгож, шинээр олгосон цолыг хураах саналыг Хорооноос Монгол Улсын Ерөнхийлөгчид өргөн мэдүүлнэ. Сэргээш хэрэглэсэн нь тогтоогдсон бөхийн баяр наадамд барилдах эрхийг 2 жил хүртэл хугацаагаар

хасах.

Найм. Бусад зүйл

8.1. Улсын баяр наадамд гоц мөргөх тооны бөх барилдуулахгүй.

8.2. Улсын баяр наадмын бөхийн барилдааны шөвгийн 16-д үлдсэн бөхчүүд сэргээшийн шинжилгээнд заавал орно.

8.3. Сэргээшийн шинжилгээнд дээж авах, хадгалах, шинжлүүлэх ажлыг Хорооноос баталсан журмын дагуу салбар хороо, Монголын үндэсний олимпын хороо хамтран зохион байгуулна.

8.4. Бөхийн барилдаантай холбогдон гарсан маргааныг салбар хороо шийдвэрлэнэ.

8.5. Салбар хорооны шийдвэрийг эс зөвшөөрвөл Хороонд хандана, Хорооны шийдвэрийг эс зөвшөөрвөл шүүхэд тус тус гомдол гаргаж болно.

Засгийн газрын 2003 оны 164 дүгээр тогтоолын 3 дугаар хавсралт

ҮНДЭСНИЙ ИХ БАЯР НААДМЫН ХУРДАН МОРИНЫ УРАЛДААНЫ ДҮРЭМ

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Үндэсний их баяр наадмын хурдан морины уралдаан (цаашид "хурдан морины уралдаан" гэх)-ыг зохион байгуулахад Үндэсний их баяр наадмын тухай хууль болон энэхүү дүрмийг мөрдөнө.

1.2. Энэхүү дүрмээр зохицуулаагүй асуудлыг Үндэсний их баяр наадмын тухай хууль болон Уяачдын их хурлаас баталсан "Хурдан морины уралдааны дүрэм"-ийг баримтлан шийдвэрлэнэ.

Хоёр. Хурдан морины уралдааны салбар хороо

2.1. Хурдан морины уралдааныг Хурдан морины уралдааны салбар хороо (цаашид "салбар хороо" гэх) хариуцан зохион байгуулна.

2.2. Салбар хорооны бүрэлдэхүүнийг Үндэсний их баяр наадмыг зохион байгуулах хороо (цаашид "Хороо" гэх)-ноос батална.

2.3. Нас бүрийн хурдан морины уралдааныг хариуцсан даамал, цуваа бүртгэлийн ахлагч, цуваа бүртгэгчид, шүдлэгч, манлайлагч, морь бариач,

цоллогч, хүний болон малын эмч нар (цаашид "шүүгчид" гэх), хянах группийг салбар хорооны хурлаас томилох бөгөөд тухайн насны морьдыг бүртгэх, дугаар олгох, уралдаанд гаргахыг салбар хороо тэдгээртэй хамтран зохион байгуулна. Бариа зохион байгуулах, цоллуулах, бай шагнал олгох, санал, хүсэлтийг хүлээн авч шийдвэрлэх, тайлан тооцоо гаргах ажлыг тухайн насны даамал хариуцна.

2.4. Салбар хорооны автомашин өөрийн таних тэмдэг, дарцагтай байна.

2.5. Салбар хороо нь дараахь арга хэмжээг хэрэгжүүлнэ:

2.5.1. Баяр наадам эхлэхээс 10 хоногийн өмнө морины бэлчээр, ус, морь шүдлэх цэг, уралдах зам, гуу жалга зэргийг шалган үзэж засаж сайжруулах, тэгшлэх, цэвэрлэх арга хэмжээ авч, морь барианы газар болон хорооны гишүүд, шүүгчдийн ажиллах байрыг засварлан тохижуулж, цахилгааны эх үүсвэр, холбооны асуудлыг шийдвэрлэх;

2.5.2. хурдан морины гарааны зурхайг нас бүрийн ангиллаар тухайн насны даамлыг оролцуулан тогтоох;

2.5.3. уяач, морь унах хүүхдийн эрүүл мэнд, уралдах морьдын аюулгүй байдлыг хамгаалах арга хэмжээ авахад дэмжлэг үзүүлэх;

2.5.4. уяач, морь унасан хүүхдэд үндэсний спортын холбоодын саналыг үндэслэн цол олгохоор Хороонд мэдүүлэх.

Гурав. Хурдан морь уралдуулах зай

3.1. Хурдан морийг насны ангиллаар нь дор дурдсан зайд уралдуулна:

1.Азарга	22-24 км
2.Их нас	24-26 км
3.Сөвөлөн	22-24 км
4.Хязаалан	17-19 км
5.Шүдлэн	12-14 км
6.Даага	10-12 км

Дөрөв. Бүртгэж, дугаар олгох

4.1. Хурдан морины уралдааны дүрмийг судалж түүнийг хүлээн зөвшөөрсөн уяач, хурдан морь унахыг эцэг, эх, асран хамгаалагч нь зөвшөөрсөн, ослын даатгалд даатгуулсан хүүхдүүд уралдаанд оролцоно.

4.2. Уяачид нь салбар хорооноос зарласан цаг, байранд өөрийн иргэний үнэмлэх, морины нас, угшлын тодорхойлолт, уралдах хүүхэд, түүний төрсний гэрчилгээ, эцэг, эх, асран хамгаалагчийн зөвшөөрөл, ослын даатгалд даатгуулсан баталгааг авч ирж бүртгүүлэн, дугаар авна.

4.3. Салбар хорооноос олгосон дугаарыг саадгүй харагдахаар морь унах хүүхдийн биед бэхлэхийг уяач хариуцна.

4.4. Бүртгэхээр зарласан цагаас хоцорсон морь, унах хүүхдийг бүртгэхгүй бөгөөд уралдаанд оролцуулахгүй.

Тав. Гарааны зохион байгуулалт

5.1. Уяачид уралдах морьдоо морь уралдах газар авчирч цуглармагц манлайлагч төрийн далбаа барьж, бүх морьдыг дагуулан индрийг нар зөв гурав тойроод гарна.

5.2. Азарга, их наснаас бусад бүх морьдыг бэлтгэсэн талбайд шүдлэх бөгөөд тухайн насны уралдаанд шүдээр тохирохгүйг нь тогтоосон бол морийг тусгай хашаанд оруулан уяж, хүүхдэд нь олгосон дугаарыг хураан авч, уралдаанд оролцуулахгүй.

5.3. Салбар хорооны тогтоосон цагаас хоцорсон морьдыг уралдаанд оролцуулахгүй.

5.4. Салбар хорооны гишүүд болон уг хорооноос томилогдсон хүмүүс хурдан морьдыг тууж гарааны зурхайд хүргэнэ.

5.5. Морьдыг гарааны зурхайд хүргэж эргүүлэхийг салбар хорооны дарга, гишүүд, тухайн насны морины даамал, тусгайлан бэлтгэсэн хүмүүс, эмнэлгийн түргэн тусламжийн ажилтнууд хамтран гүйцэтгэнэ.

5.6. Морьдыг гарааны зурхайгаас даамлын дохиогоор эргүүлнэ.

5.7. Гарааны зурхайд хүрээгүй байхад морь эргүүлэх болон ийм оролдлого хийхийг хориглоно.

Зургаа. Уралдааны үеийн зохион байгуулалт

6.1. Тухайн насны уралдааныг хариуцсан даамал төрийн далбаа байрлуулсан машинаар уралдааны үед эхний мориноос 100 метрээс багагүй зайд замчлан явна.

6.2. Хүн эмнэлгийн тусламжийн хэсэг морьдын ард явж унасан хүүхдэд эмнэлгийн тусламж үзүүлнэ.

6.3. Мал эмнэлгийн тусламжийн хэсгүүд уралдааны замын дагуу тогтоосон цэгт байрлаж, шаардлагатай үед тусламж үзүүлнэ.

6.4. Уралдааны замаас морь гарах, гаднаас морь орж ирэх зэрэг болзошгүй үйлдлүүдийг хянах хэсгийг нас бүрт томилно.

6.5. Хурдан морины салбар хорооноос зөвшөөрөл авсан сурвалжлагч, сэтгүүлчид уралдаанд саад болохгүйгээр морьдыг дагах нэвтрүүлэг, бичлэг хийж болно.

6.6. Уралдааны замаас морь оруулах, хөөх, саад хийх, уралдаж байгаа морьдыг тосон цулбуурдаж хөтлөх, морь тавих зорилгоор хүн явуулахыг хориглоно.

6.7. Салбар хорооноос зөвшөөрөл авсан автомашинаас бусад автомашин морины уралдааныг дагахыг хориглоно.

Долоо. Барианы зохион байгуулалт

7.1. Барианы зурхайг цагаан шугамаар тэмдэглэсэн байна.

7.2. Айргийн таван морийг морь бариачид барьж бусад морьдыг барианы зурхайд ирсэн дарааллаар нь хүүхдийн дугаар, дүрс, дуу бичлэгийн техник хэрэгсэл ашиглан байр эзлүүлнэ.

7.3. Барианд орсон морьдыг дөрвөөс доошгүй дуудагчийн цуваа болон зурхайн баруун, зүүн талаас бичсэн дүрс бичлэгийн дүнг харьцуулан байр эзлүүлэн бүртгэнэ. Маргаантай асуудлыг тухайн насны даамал нь салбар хороо болон шүүгчдийн хамтарсан хуралд оруулж шийдвэрлүүлнэ.

7.4. Хүүхэдгүй уралдаж ирсэн морийг нэг байр ухрааж барина.

7.5. Жолоогий нь дэл сойлго, эмээлд нь уяж бэхэлсэн зэрэг зориуд зохион байгуулж, хүүхэдгүй ирсэн морийг уралдаанаас хасна.

7.6. Азарга, их наснаас бусад насанд айрагдсан морьдыг уралдааны дараа дахин шүдлэх бөгөөд шүдээр тохирохгүй нь тогтоогдвол уралдаанаас хасч дараагийн морийг урагшлуулж байр эзлүүлнэ.

7.7. Морьд барианд зэрэгцэн орсон бол барианы зурхайг түрүүлж хошуу нь давсан морийг, морьдын хошуу зэрэгцэн тохиолдолд зөв талын морийг түрүүлж барих бөгөөд үүнийг дуудагчийн цуваа болон дүрс бичлэгийн техник хэрэгслийг ашиглан тогтооно.

Найм. Цол, бай шагнал

8.1. Баяр наадамд түрүүлсэн, айрагдсан морьдын уяачдад Үндэсний их баяр наадмын тухай хуульд заасан цол олгоно.

8.2. Нас тус бүрийн уралдаанд уралдсан морьдын 30 хүртэл хувийг барьж, бай шагнал олгоно.

8.3. Барианд орсон морьдын бай шагналыг 7 дугаар сарын 11, 12, 13-ны өдөр салбар хорооны барианд олгоно.

8.4. Хурдан морины уралдааныг ивээн тэтгэсэн гадаад, дотоодын байгууллага, аж ахуйн

нэгж, иргэд өөрсдийн хөрөнгөөр уяач болон морь унасан хүүхдийг шагнаж урамшуулж болох бөгөөд шагналыг зөвхөн уяачдын баярын үеэр олгоно.

Ес. Хурдан морины уралдааны тайлан

9.1. Тухайн насны морины уралдааныг хариуцсан даамал нь оролцсон морины тоо, түрүүлсэн, айрагдсан болон барианд орсон морьдын бүртгэл, олгосон бай шагнал, эмнэлгийн тусламж үзүүлсэн тухай болон дараа жилийн уралдаанд анхаарах асуудлын талаар тодорхой санал бүхий тайланг салбар хороонд өгнө.

9.2. Салбар хороо тайланг нэгтгэж баяр наадмын хурдан морины уралдаан зохион байгуулсан тухай нэгдсэн тайлан гаргаж, зардлын тооцоог хавсарган Үндэсний их баяр наадмыг зохион байгуулах хороонд хүргүүлнэ.

Арав. Бусад зүйл

10.1. Улсын их баяр наадамд айрагдсан бүх морийг сэргээшийн шинжилгээнд оруулна.

10.2. Сэргээшийн шинжилгээнд дээж авах, хадгалах, шинжлүүлэх ажлыг Хорооноос баталсан журмын дагуу салбар хороо, Монголын үндэсний олимпын хороо хамтран зохион байгуулна.

10.3. Хурдан морины уралдаантай холбогдон гарсан маргааныг салбар хороо шийдвэрлэнэ.

10.4. Салбар хорооны шийдвэрийг эс зөвшөөрвөл Хороонд, Хорооны шийдвэрийг эс зөвшөөрвөл шүүхэд тус тус гомдол гаргаж болно.

Арван нэг. Хариуцлага

11.1. Энэхүү дүрмийг зөрчсөн буруутай этгээдэд хууль тогтоомжид заасны дагуу хариуцлага хүлээлгэнэ.

Засгийн газрын 2003 оны 164 дүгээр тогтоолын 4 дүгээр хавсралт

ҮНДЭСНИЙ ИХ БАЯР НААДМЫН ҮНДЭСНИЙ СУРЫН ХАРВААНЫ ДҮРЭМ

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Үндэсний их баяр наадмын сурын харваа (цаашид "Үндэсний сурын харваа" гэх)-г зохион байгуулахад Үндэсний их баяр наадмын тухай хууль болон энэхүү дүрмийг мөрдөнө.

1.2. Үндэсний сурын харвааны хэрэгсэл, харвааны бай болон зай, харваач, шүүгчдийн эрх,

үүргийг Халх сурын цуваа харвааны дүрэмд зааснаар зохицуулна.

Хоёр. Сурын харвааны салбар хороо

2.1. Үндэсний их баяр наадмын үндэсний сурын харвааг Сурын харвааны салбар хороо (цаашид "салбар хороо" гэх) хариуцан зохион байгуулна.

2.2. Салбар хорооны брээлдэхүүнийг Үндэсний их баяр наадмыг зохион байгуулах хороо (цаашид "хороо" гэх) батална.

2.3. Сурын харвааны шүүмтийг Үндэсний сурын холбоотой тохиролцон салбар хорооноос томилсон шүүгчдийн зөвлөл гүйцэтгэнэ.

Гурав. Харваачдыг бүтгэх

3.1. Үндэсний сурын харвааг эрэгтэй, эмэгтэй, хөвгүүд, охид гэсэн аниллаар зохион байгуулна.

3.2. Харваачид нь салбар хорооноос зарласан хугацаанд иргэний үнэмлэхтэйгээ биеэр ирж бүртгүүлэх бөгөөд цолтой харваачид цолны үнэмлэхтэй байна.

3.3. Бүртгэлээс хоцорсон харваачийг харваанд оруулахгүй.

Дөрөв. Харвааны дунгаргах

4.1. Харваачдыг хана болон хасаа суранд оносон онооны нийлбэрээр цуваагаар байр эзлүүлнэ.

4.2. Ижил оноотой харваачдыг товх харвуулж шаггаруулна.

4.3. Түрүүлсэн харваачдад Үндэсний их баяр наадмын тухай хуульд заасан цол олгоно.

4.4. Түрүүлсэн харваачийн онооны 50 хувиас дээш оноотой харваачдад байр шагнал хүртээнэ.

Тав. Бусад зүйл

5.1. Сурын харвааны үед дараахь зүйлсийг хориглоно:

5.1.1. үндэсний сурынхаас өөр төрлийн харвааны хэрэгслээр харваанд оролцох;

5.1.2. эрхийвчлэхээс өөр арга барилаар харваа үйлдэх.

5.2. Аймаг, сумын баяр наадмын сурын харвааг зохион байгуулахад энэ дүрэм болон Халх сурын цуваа харвааны дүрмийг мөрдөнө.

5.3. Үндэсний их баяр наадмын сурын харваанд эхний 3 байр эзэлсэн харваач сэргээшийн шинжилгээнд заавал орно.

5.4. Сэргээшийн шинжилгээнд дээж авах, хадгалах, шинжлүүлэх ажлыг Хорооноос баталсан журмын дагуу салбар хороо, Монголын үндэсний олимпын хороо хамтран зохион байгуулна.

5.5. Сурын харваатай холбогдон гарсан маргааныг салбар хороо шийдвэрлэнэ.

5.6. Салбар хорооны шийдвэрийг эс зөвшөөрвөл Хороонд, Хорооны шийдвэрийг эс зөвшөөрвөл шүүхэд тус тус гомдол гаргаж болно.

Зургаа. Хариуцлага

6.1. Энэхүү дүрмийг зөрчсөн салбар хорооны гишүүд, шүүгч, харваачдад хууль тогтоомжийн дагуу хариуцлага хүлээлгэнэ.

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2003 оны 7 дугаар сарын 4-ний өдөр

Дугаар 167

Улаанбаатар хот

Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх зорилгоор Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

Монголын бүх ард түмний XI спартакиадыг 2004 онд орон даяар зохион байгуулахыг Эрүүл мэндийн сайд П.Нямдаваа, аймаг, нийслэлийн

Монголын бүх ард түмний спартакиад зохион байгуулах тухай Засаг дарга нарт үүрэг болгосугай.

МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ САЙД

Н.ЭНХБАЯР

ЭРҮҮЛ МЭНДИЙН
САЙД

П.НЯМДАВАА

Монгол Улсын Их Хурлын Тамгын газраас гаргаж.
Хаяг: <<Төрийн мэдээлэл>> эмхтгэлийн зөвлөл.

Улсын Их Хурлын Тамгын газрын
Хэвлэх хэсэгт хэвлэв.

Улаанбаатар-12
Төрийн ордон

☎ 329612
Индекс 14003

☎ 329487
Хэвлэлийн хуудас 2